



УВС АЙМАГ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/21

Улаангом

“Төрийн албан хаагчийн сургалт,
ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны
хөтөлбөр”-ийг батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.6 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын 2026-2029 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” батлагдсантай холбогдуулан “Төрийн албан хаагчийн сургалт”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангахыг Тогтоол шийдвэр, тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн (Х.Баяртуул)-д, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Өлзийхишиг)-д тус тус үүрэг болгосугай.

3. “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүр байгууллагын үйл ажиллагааны төсөвт батлуулж, тухай бүр санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн) –д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.БАДАРЧ



Биеийн тамир, спортын газрын даргын
2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн
А/21 дүгээр тушаалын хавсралт



ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн нийтлэг үндэслэл

1.1 Хөтөлбөр боловсруулах үндэслэл:

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3-д “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан бөгөөд төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулах хууль, эрх зүйн үндэс нь болно.

Төрийн байгууллага бүр чиг үүрэг, зорилтоо хэрэгжүүлэх, иргэдэд чанартай төрийн үйлчилгээ үзүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж буй төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтын хэрэгцээ, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг тодорхойлох суурь судалгааны дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийг үндсэн 4 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг төлөвлөсөн.

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, Эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь тэдний амьжиргааны үндэс болсон цалин хөлсийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын зохих хураамжийг төр хариуцах, төрийн зардлаар давтан сургах, мэргэжлээ дээшлүүлэх, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалынхаа цалин хөлсийг авах, эмчилгээ, оношилгоонд хамрагдах зэрэг нийгмийн баталгаагаар хангагдах зэрэгт үйлчилнэ.

1.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Биеийн тамир, спортын газрын “Төрийн албан хаагчийн ажиллах сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

1.2.1 Хууль тогтоомж, салбарын бодлогын баримт бичигтэй уялдсан байх;

1.2.2 Хэрэгжилт ил тод, нээлттэй, тэгш байх;

1.2.3 Байгууллагын хамтын ажиллагаа, дэмжлэгт түшиглэх;

1.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2026-2030 онд үргэлжлэх бөгөөд хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг агентлагийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамтай уялдуулах, “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр шинэчлэн батлуулах, хэрэгжилтийг хангах замаар үр дүнд хүрнэ.

Хоёр. Хүний нөөцийн удирдлага, өнөөгийн нөхцөл байдал

Аливаа байгууллагын ажилтан, албан хаагчдын ажил үүрэгтээ хандах хандлагад ажлын байрны орчин нөхцөл, байгууллагын бодлого, зорилт, нийгмийн хангамж зэрэг



олон хүчин зүйлд нөлөөлдөг бөгөөд албан хаагчдын сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийг дараах байдлаар ангилж үздэг байна. Үүнд:

Аймгийн Биеийн тамир, спортын газрын батлагдсан орон тоо 23, өнөөдрийн байдлаар 21 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс ТЗ-ны хаагч 5, ТҮМ-2, ТҮСБ-5, ТҮ-ний 9 албан хаагч тус тус ажиллаж байна.

Нийт ажиллагсадын 12 буюу 57,1 хувь нь эрэгтэйчүүд, 9 буюу 42,9 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна. Хүйсийн тэнцвэрт байдал 57:43 харьцаатай

Насны байдлаар нь авч үзвэл, 25-30 настай 3 буюу **14.3 хувь**, 31-35 настай 3 буюу **14.3 хувь**, 36-40 настай 2 буюу **9.6 хувь**, 41-45 настай 1 буюу **4.8 хувь**, 46-50 настай 4 буюу **19 хувь**, 51-55 настай 4 буюу **19 хувь**, 56-аас дээш насны 4 буюу **19 хувийг** тус тус эзэлж байна. Албан хаагчдын дундаж нас 44,4 байна.

Боловсролоор нь авч үзвэл магистр 4 буюу **19 хувь**, бакалавр 8 буюу **38 хувь**, тусгай дунд боловсролтой 1 буюу **4,7 хувь**, бүрэн дунд боловсролтой 8 буюу **38 хувь** байна.

Мэргэжлээр нь ангилбал биеийн тамирын багш, дасгалжуулагч мэргэжилтэй 8 буюу **38 хувь**, бусад мэргэжилтэй 5 буюу **23,8 хувь**, **38,2 хувь** нь тодорхой эзэмшсэн мэргэжилгүй байна. Эдгээр албан хаагчид голдуу үйлчилгээний ажилтнууд байна.

Албан хаагчдын өрхийн ам бүлийн бүтцийг тодорхойлбол: Нийт ажиллагсадын **23,8 %** нь 2-3 ам бүлтэй, **66,6 %** нь 4-6 ам бүлтэй, 8 ам бүлтэй **4,8 %**, **4,8 %** нь гэр бүлгүй байна.

Төрийн албанд ажилласан жилээр нь авч үзвэл 1 хүртэл жил ажилласан 2, 2-6 жил ажилласан 4, 7-12 жил ажилласан 6, 13-19 жил ажилласан 3, 20-24 жил ажилласан 4, 25-с дээш жил ажилласан 2 ажилтан тус тус ажиллаж байна.

Албан хаагчдыг орон байрны хувьд авч үзвэл **38,0 %** нь төвийн халаалттай нийтийн орон сууцанд, төвийн халаалттай хувийн орон сууцанд **38,0 хувь**, **24 хувь** нь монгол гэрт амьдарч байна.

Нийт албан хаагчдад хоол унааны зардалд 2025 онд 54,492,0 сая төгрөг олгосон бөгөөд 2026 онд өдрийн 12,0 мянган төгрөгөөр, мөн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдэл, ТАХ-дын төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, төрийн үйлчилгээний ажилтнуудын ур чадварын нэмэгдлийг тус тус олгож байна.

Гурав: Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь:

- ✓ Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж, эрүүл мэндийг хамгаалах, ажил мэргэжлийн даатгал, амралт сувилалын үйлчилгээнд хамруулах, асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;
- ✓ Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж, төрийн бодлого, шийдвэрийг орон нутагтаа хэрэгжүүлэх, иргэдийн эрүүл чийрэг, иргэн хүн болгон төлөвшүүлэх,

иргэдийн зөвлөгөө дэмжлэгээр хангахуйц мэдлэг, манлайлах, ур чадвартай, мэргэшсэн албан хаагч бүхий байгууллага болоход оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээ

Зорилт 1: Төрийн албан хаагчдын албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх, мэдлэг, ур чадвар, арга зүйг өргөн хүрээнд эзэмшүүлэх боломж, нөхцлийг хангана.



Хэрэгжүүлэх арга хэмжээ

1.1.1. Албан хаагчдын сурч боловсрох нөхцлийг бүрдүүлэх, мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх

1.2. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд чиглүүлэх, богино хугацааны болон албан тушаалын мэргэшүүлэх сургалтын зардлыг байгууллагын төсөвт жил бүр тусгаж, сургалтын эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах;

1.3. Богино хугацааны сургалтаар мэргэшлийг нь дээшлүүлэх;

1.4. Тодорхой чиглэлийн зорилтот сургалтад давтан сургах;

1.5. Албан тушаалын тодорхойлолтод заасан тавигдах шаардлагын дагуу мэргэшэх сургалтад хамруулах;

1.6. Албан хаагчдыг гадаад, дотоодын их дээд сургуульд мэргэжлийн чиглэлээр давтан сургахад дэмжлэг үзүүлэх;

1.7. Эрхэлж буй ажил үүргийн чиглэлийн дагуу гадаад улсад богино хугацааны сургалт, семинар, зөвлөгөөнд явуулах;

1.8. Төрийн албан хаагчдыг ажил үүргээ хэрэгжүүлэх, практик чадварыг сайжруулах зорилгоор ижил чиг үүргийн байгууллагуудын /нийслэл буюу бусад аймаг/ ажлын дэвшилтэт арга барил, сайн туршлагыг судалж, суралцахад нь дэмжлэг үзүүлэх;

Зорилт 2. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, ажлын байрны орчин, нөхцлийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1 Албан хаагчдад эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх тухай мэдлэг боловсрол олгох;

2.2 Албан хаагчдыг жилд 1-ээс доошгүй удаа нарийн мэргэжлийн оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтуудад үе шаттайгаар хамруулж, шаардлагатай хүмүүсийг эмнэлэгийн үйлчилгээ, амралт сувилалд явуулах;

2.3 Эрүүл мэндийн шалтгаанаар гадаад дотоодод эмчлүүлэхэд хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу санхүүгийн тусламж үзүүлэх, рашаан сувилалд амруулах зэрэгт хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх.

2.4 Хамт олныг идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, ажил мэргэжлийн уралдааныг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, албан хаагчдыг хамруулах, шагнаж урамшуулах;

2.5 Хөрш зэргэлдээ болон бусад гадаадын улс орнуудын төрийн байгууллагуудтай туршлага солилцож хамтран ажиллах, төрийн албан хаагчдыг гадаад улс оронд сургалтад хамруулах, аялуулах ажлыг зохион байгуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх

2.6 Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг хөгжүүлэх хүрээнд ажил эрхлэлтэд хүйсийн тэнцвэрт байдлыг хангахад анхаарч, сэтгэл зүйн зөвлөгөө, сургалт мэдээлэлд албан хаагчдыг хамруулах замаар ажлын байрны дарамтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.7 Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичгийн хэрэгсэл, компьютер, бусад техник хэрэгслээр хангах, мэдээлэлийн сүлжээгээр холбох;

2.8 Албан хаагчдыг хөдөлмөрийн тухай хуулийн дагуу илүү цаг болон шөнийн цагаар ажиллах тохиолдолд биеэр нөхөн амрах, өөр аймаг, сумд ажиллахад албан томилолтыг олгох, жил бүрийн төсөвт тусгах;

2.9 Албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллэх зорилгоор 7 хоног бүрийн Лхагва гарагт “Эрүүл мэндийн цаг” арга хэмжээ зохион байгуулах.;

Зорилт 3. Төрийн албан хаагчийн цалин хөлс олгох, нөхөн төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр тэтгэмжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох.

3.1 Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн сан”, Сангийн яамны “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем”-д төрийн албан хаагчдын хувийн хэрэг, цаг бүртгэл, сургалт, цалин хөлс, сахилгын болон ёс зүйн зөрчил, чөлөө олголт, ажлаас чөлөөлөгдөх зэрэг холбоотой бүх мэдээллийг тухай бүр оруулах, баяжилт хийх, тайлан мэдээг гаргах;

3.2 Монгол гэр болон ердийн галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад жил бүр хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу түлээ нүүрсний хөнгөлөлт олгох, ганц бие болон өрх толгойлсон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд болон шинээр гэр бүл болсон залуу гэр бүлд ажилтны хүсэлт, амьжиргааны төвшнийг харгалзан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тусламж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.3 Албан хаагчдын ажилдаа ирэх, буцах унааны болон өдрийн хоолны мөнгийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, илүү цагийн нэмэгдэл хөлсийг ажлын зайлшгүй шаардлагаар ажилласан төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад холбогдох хууль, журмын дагуу олгох;

3.4 Нэг сараас дээш хугацаатай ажил хавсран гүйцэтгэж байгаа тохиолдолд тус ажилтны гүйцэтгэвэл зохих ажлын үр дүн, чанарыг харгалзан үндсэн цалингийн 10-40 % тай тэнцэх нэмэгдлийг олгох;

3.5 Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, албан хаагчдад эмнэлэгийн болон бусад шаардлагатай үйлчилгээг авахад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх;

Зорилт 4. Төрийн албаны тухай хууль, журмын хүрээнд агентлагийн



хөдөлмөрийн дотоод журам болон шаардлагатай дүрэм, журмыг шинэчилж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх арга зам

4.1 Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын зохицуулалтын хүрээнд тэтгэмж, тусламж, урамшуулал олгохтой холбоотой харилцааг хууль, тогтоомжид нийцүүлэн цалин хөлсний журмаар зохицуулах;

4.2 Хууль тогтоомжийн хүрээнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шаардлага хангасан тухай бүр, ТЗ-ны албан хаагчдад зэрэг дэв, төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадвар, улирлын мөнгөн урамшууллыг тухайн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын үр дүнтэй уялдуулан олгож, төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хангах;

4.3 Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, эерэг харилцаа хандлага, мэргэшсэн, тогтвортой үйл ажиллагааны шалгуурыг харгалзан албан хаагчдыг агентлагийн болон засгийн газар, төрийн дээд цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлох;

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

5.1. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.1.1. Улс, орон нутгийн төсөд

5.1.2. Хууль тогтоомжид нийцсэн гадаад улсын болон олон улсын төрийн болон төрийн бус байгууллагын тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр

5.1.3 Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр

Зургаа: Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хяналт шинжилгээ, үнэлгээ

6.1 Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтийг баримтлан өссөн дүнгээр болон гүйцэтгэлээр тус тус үнэлнэ.

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт		Хэмжих нэгж Мян.төг	Суурь түвшин	
					2025	2026
	ТАХ-чдын албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх, мэдлэг, чадвар, арга зүйг өргөн хүрээнд эзэмшүүлэх боломж, нөхцлийг хангана.	Сургалтад зарцуулсан санхүүжилт				
		ТАХ-ыг мэргэшүүлэх эх сургалтад хамруулсан дүн	Албан тушаалын мэргэшүүлэх	тоо	Өссөн дүнгээр	Өссөн дүнгээр
			Ажил үүргийн мэргэшэх	тоо	Өссөн дүнгээр	Өссөн дүнгээр
	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, ажлын байрны орчин нөхцлийг дээшлүүлнэ.	Ажлын байрны ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад зарцуулсан хөрөнгө оруулалт		тоо	Өссөн дүнгээр	
		Цахим систем, компьютер техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулахад зарцуулсан хөрөнгө оруулалт		Мөнгөн дүн	Өссөн дүн	

		Хөдөлмөрийн дотоод журмын дагуу эмчилгээ, оношилгооны зардалд олгосон санхүүжилт	Мөнгөн дүн	Өссөн дүн	Өссөн дүн
Албан хаагчдын нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа бүртгэл, мэдээллийг сайжруулж, тэдний нийгмийн баталгааг үе шаттайгаар дээшлүүлнэ.		Амьжиргааны дэмжлэгт үзүүлсэн хөрөнгийн хэмжээ	Мөнгөн дүн	Өссөн дүн 9065334	Өссөн дүн 1524850002
		Хоол, унааны нөхөх төлбөрт зарцуулсан хөрөнгө	Мөнгөн дүн	Өссөн дүн	Өссөн дүн
		Хөдөлмөрийн дотоод журмын дагуу олгосон тусламж, дэмждэг, хамрагдсан албан хаагчид	тоо	Өссөн дүнгээр	Өссөн дүнгээр
	Төрийн албан хаагчийн тухай хууль, журмын хүрээнд агентлагийн хөдөлмөрийн дотоод журам болон шаардлагатай дүрэм, журмыг шинэчилж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Шинээр болон шинэчлэн батлуулсан журам	тоо	Өссөн дүнгээр	Өссөн дүнгээр
		Орон нутагт ажилласан хугацааны мөнгөн урамшуулалд хамрагдсан албан хаагч, олгосон санхүүжилтийн дүн	Мөнгөн дүн	Өссөн дүн	Өссөн дүн

Жил бүрийн 12 дугаар сард багтаан хөтөлбөрийн хэрэгжилтийг хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн нэгтгэн Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд хүргүүлж, хамт олны хурлаар тайлагнана.

6.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн дараах үзүүлэлтээр тодорхойлогдоно. Тухайлбал:

- Албан хаагчийн тогтвор суурьшил, эрхэлсэн ажлын бүтээл, үр дүн дээшилнэ.
- Холбогдох хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдлэх боломжоор хангагдана.
- Ажилтнуудын орон сууцны нөхцөл, хангамж сайжирна.
- Эрүүл мэндээ хамгаалах, эрүүлжих, чийрэгжүүлэх арга барилтай болж эрүүл мэндийн байдал сайжирна.
- Албан хаагчдын ажиллах нөхцөл, техник хэрэгслийн хангамж сайжирна.
- Албан хаагчдын эрх зүйн мэдлэг, баримт бичиг боловсруулах чадвар дээшилнэ.
- Албан хаагчдын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх боломжоор хангагдана.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт:

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, биелэлтийг дүгнэх үүргийг Биеийн тамир, спортын газрын удирдлагын зөвлөл, ХШҮ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцана.